



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 24/22

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 80 дугаар зүйлийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга баригдах болсонтой холбогдуулан Чингэлтэй дүүрэгт байрлах 74 дүгээр цэцэрлэгийн баланст бүртгэлтэй нийт 512,065,035.00 (таван зуун арван хоёр сая жаран таван мянга гучин тав) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 167,124,645.80 (нэг зуун жаран долоон сая нэг зуун хорин дөрвөн мянга зургаан зуун дөчин таван төгрөг наян мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 344,940,389.20 (гурван зуун дөчин дөрвөн сая есөн зуун дөчин мянга гурван зуун наян есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад дурдсан цэцэрлэгийн хуучин барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА



А.БАЯР

1110101055

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн
2024/11 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ 74 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тос ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Барилга	43	ш	1	487,503,315.00	487,503,315.00	153,096,212.70	334,407,120.30
2	Дулааны шугам	43	м	14	690,480.00	9,666,720.00	4,699,100.00	4,967,620.00
3	Цэвэр бохирын шугам	43	м	100	130,000.00	13,000,000.00	7,583,333.10	5,416,666.90
4	Мод навчит		суулгац	20	7,450.00	149,000.00		149,000.00
НИЙТ ДҮН						512,065,035.00	167,124,645.80	344,940,407.20